



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2022 оны 11 сарын 08 өдөр

Дугаар 199

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/867, Баянзүрх дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2022 оны А/53 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Нийслэлийн хөрөнгө оруулалтаар бий болсон, нийт 44,400,000.00 (дөчин дөрвөн сая дөрвөн зуун мянган) төгрөгийн балансын үнэ, 17,400,000.00 (арван долоон сая дөрвөн зуун мянган) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, хурандаа О.Амарсанаа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Автомашиныг улсын бүртгэлээс шилжүүлэн авч арга хэмжээний биелэлтийг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132003488

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны дүгээр сарын 08 өдрийн
дугаар тогтоолын хавсралт

НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР БИЙ БОЛСОН ХӨРӨНГИЙГ ТӨРИЙН ӨМЧИД ХҮЛЭЭН АВЧ,
НИЙСЛЭЛИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗАРТ БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк, арал, хөдөлгүүрийн дугаар	Ашиглалтад орсон, бүртгэсэн орсон ОН	Нийт гүйлт /км/	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Приус-30, шинэ (арал-zvw301617068)	2014/2022	156479	26,400,000.00	0.00	26,400,000.00
2	Соната-7, 01-48 УБЗ (арал-kmhec41bea656344)	2014/2022	184560	18,000,000.00	17,400,000.00	600,000.00
	Нийт дүн			44,400,000.00 (дөчин дөрвөн сая дөрвөн зуун мянган)	17,400,000.00 (арван долоон сая дөрвөн зуун мянган)	27,000,000.00 (хорин долоон сая)